



## ОНЧ ШИЙДЭЛ ТББ

ЯАМД, УИХ-ЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН 2014 ОНЫ  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

## ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Монгол Улс, Улаанбаатар хот,  
2014 оны 12 сарын 05-ны өдөр

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ГРАФИКЫН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

1. “ЯАМД БОЛОН УИХ-ЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН АВЛИГЫН ЭСРЭГ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН”
  - 4.1. АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ
  - 4.2. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
  - 4.3. ОЛОЛТ, АМЖИЛТ
  - 4.4. НИЙТЛЭГ ДУТАГДАЛТАЙ ТАЛ
  - 4.5. САЙН ТУРШИЛГА
  - 4.6. СУДАЛГААНЫ ДҮН
  - 4.7. ДҮГНЭЛТ
5. САНАЛ, ЗӨВЛӨМЖ
6. ХАВСРАЛТУУД

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1	Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний нэгтгэл (Яам)
Хүснэгт 2	Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний нэгтгэл (УИХ-ын дэргэдэх байгууллага)
Хүснэгт 3	Шалгуур үзүүлэлт бүлэг тус бүрийн гүйцэтгэлийн хувь хэмжээ
Хүснэгт 4	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны үр дүн
Хүснэгт 5	Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний хүснэгтийн шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн хувь

## **ГРАФИКЫН ЖАГСААЛТ**

График 1	Яамдын авлигын эсрэг үнэлгээний дүн 2013, 2014 оны харьцуулалт
График 2	УИХ-ын дэргэдэх байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ харьцуулалт
График 3	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны асуумж 1
График 4	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны асуумж 2
График 5	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны асуумж 3
График 6	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны асуумж 7
График 7	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны асуумж 8
График 8	Авилгатай тэмцэх үйл ажиллагааны менежментийн үр өгөөжийг тодорхойлох судалгааны асуумж 11

## УДИРТГАЛ

Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын захиалгаар хүрээнд хууль зүйн судалгааны “Онч шийдэл” ТББ-аас Яамд, УИХ-ын харьяа байгууллагуудын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийж, Авлигын эсрэг хуулийн 6-р зүйл болон холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээн үүргийн биелэлт, тухайн байгууллагын авлигын эсрэг санал санаачлага зэргийг Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 11 сарын 14-ны 122 тоот тушаалын хавсралтаар баталсан “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэн энэхүү тайланг бэлтгэн гаргав.

Үнэлгээг нээлттэй сонгон шалгаруулалтын дүнд шалгарсан хөндлөнгийн хууль зүйн судалгааны “Онч шийдэл” ТББ Авлигатай тэмцэх газартай байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-ны дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний ажлын үр дүн, тайлан нь Авлигатай тэмцэх газрын байр суурь, саналыг агуулаагүй бөгөөд зөвхөн хөндлөнгийн судлаачдын үнэлгээний ажлын үр дүн болно.

### Зорилго:

Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагуудын тухайн жилийн авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт өгч тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн хэрэгжилт авлигын эсрэг хамт олон, удирдлагын хүсэлт эрмэлзэл идэвхи чармайлтыг үнэлэх, тэдгээрийн ололт амжилт, нийтлэг алдаа дутагдлыг тодорхойлох, тэдгээрийн авлигын эсрэг үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг нэг мөр хангуулахад дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний ажлын зорилго оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

1. Тухайн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх;
2. Сонгосон байгууллагуудад газар дээр нь ажиллаж үнэлгээг баталгаажуулах
3. Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагуудын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гарсан ололт үр дүн, сайн туршлага, алдаа дутагдлыг тодорхойлох;
4. Үнэлгээний үр дүнгээр нэгдсэн жагсаалт гаргаж 2014 онд авлигын эсрэг үйл ажиллагааг амжилттай болон хангалтгүй гүйцэтгэсэн байгууллагуудын тодорхойлох;
5. Авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах талаарх санал, зөвлөмжийг гаргаж захиалагчид хүргүүлэх;
6. Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын 2014 оны “Авлигын эсрэг үйл ажиллагаа” –нд өгсөн үнэлгээний үр дүнг олон нийтэд танилцуулах;

### Хамрах хүрээ:

2014 онд бүтэн үйл ажиллагаа явуулсан тул татан буугдсан болон нэгдсэн яамдын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг тус бүрт нь гаргаж нийт 16 яам болон УИХ-аас дэргэдэх нийт 7 байгууллагын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

### Хугацаа:

2014 оны 11 сарын 15-наас 2014 оны 12 дугаар сар 5-ны өдөр хүртэлх ажлын 15 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэв.

#### Арга зүй:

Үнэлгээг Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 11 сарын 14-ны 122 тоот тушаалын хавсралтаар баталсан “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

Тус үнэлгээг баримт бичиг судлах, цахим хуудас холбогдох мэдээллийн эх сурвалжид шинжилгээ хийх, ажилчин албан хаагчдаас асуулгын судалгаа авах, газар дээр нь ажиллаж ажиглалт дүгнэлт хийх зэрэг судалгааны аргуудыг ашиглан хийж гүйцэтгэв.

Үнэлгээнд ашигласан эх сурвалж

- Дээрх байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллаганы төлөвлөгөө тайлан, хавсралтаар ирсэн нотлох баримтууд,
- Байгууллагын цахим хуудас,
- Газар дээр нь ажиллаж гаргуулан авсан баримт, нотолгоо,
- Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн бүртгэл,
- Тухайн жилд шийдэгдсэн авлигын гэмт хэргийн бүртгэл;
- Авлигатай тэмцэх газраас авагдсан зөрчил арилгуулах, хариуцлага оногдуулсан арга хэмжээний бүртгэл,
- Тухайн байгууллагуудтай холбогдох авлигатай тэмцэх газарт ирүүлсэн өргөдөл гомдлын бүртгэл,
- Асуулгын судалгааны дүн,

#### Үнэлгээний ажлын зохион байгуулалт:

“Онч шийдэл” ТББ нь Авлигатай тэмцэх газраас зарласан нээлттэй сонгон шалгаруулалад тэнцэж хуульч, судлаач Ө.Эрдэнэ-Очир, А.Зоригтбаатар, Ш.Алтангадас, Т.Багахүү нараас бүрдсэн шинжээчдийн бүрэлдэхүүнтэйгээр энэхүү ажлыг гүйцэтгэсэн бөгөөд шинжээчдийн баг дүн шинжилгээ хийх удирдамж, ажлын төлөвлөгөө гарган, түүний дагуу хийж гүйцэтгэв.

Шинжээчдийн баг доорх зарчмыг удирдлага болгон ажиллав. Үүнд:

- Төрийн болон бусад байгууллагаас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүйгээр судалгааны ажлыг гүйцэтгэх;
- Бодит мэдээлэл, нотлох баримтанд тулгуурлан шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх;
- Үнэлгээний чанарыг сайжруулах, баталгаажуулах зорилгоор санамсаргүй сонголтын зарчимаар газар дээр нь очиж ажиллах;

Үнэлгээний бодит байдал, хамрах хүрээ, чанарыг баталгаажуулахын тулд санамсаргүй сонголтоор нийт 4 яамыг сонгон авч газар дээр очиж, бодит нөхцөлд нь ажиллаж үнэлгээ хийсэн болно. Үүнд:

#### Яамдаас

- Эрчим хүчний яам
- Сангийн яам
- Уул уурхайн яам

○ Барилга, хот байгуулалтын яам  
УИХ-ын дэргэдэх байгууллагуудаас

- Төрийн албаны зөвлөл
- Хүний эрхийн үндэсний комисс

## ЯАМД БОЛОН УИХ-ЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНИЙ ҮНЭЛГЭЭ

Яамд болон УИХ-ын дэргэдэх байгууллагуудын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэн, дүгнэлт өглөө. Байгууллагууд тайлангаа ирүүлэхдээ Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн товъёогийн загварын дагуу тайлангийн хавсралт, нотлох баримтуудын жагсаалт гаргаж ирүүлсэн нь өмнө жилийнхтэй харьцуулахад дэвшилттэй болсон бөгөөд үнэлгээ хийх ажиллагаанд амар төхөм болсон байсныг дурьдах хэрэгтэй.

Энэ оны яамдад өгөх үнэлгээний хувьд 2014 оны 10 сарын 08-ны “Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу бүтэц зохион байгуулалтын өөрчлсөн үетэй давхцаж байгаагаараа онцлог байлаа. Хэдий тийм боловч татан буугдсан болон нэгдсэн яамд нь тухайн жилд бүтэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, авлигын эсрэг төлөвлөгөө, хагас жилийн тайлан хүргүүлэн ажилласан гэдэг утгаараа тухай бүрт нь буюу өмнөх бүтцийн хүрээнд үнэлэлт дүгнэлт өгсөн.

Үнэлгээний ажлын гол эх сурвалж болсон Авлигатай тэмцэх газраас боловсруулан гаргасан “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу тухайн байгууллагаас өгсөн үнэлэх ерөнхий чиглэлийг баримтлан үнэлгээг гүйцэтгэсэн.

Үнэлгээ хийхэд 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй хоёр байгууллага байсан ба тэдгээрийн цахим хуудас болон өөр үнэлгээнд ашиглаж болох бусад мэдээллийн эх сурвалж, материалуудыг үндэслэн үнэлгээг хийж харгалзах оноог өгсөн.

Эдийн засгийн хөгжлийн яам нь 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан ирүүлээгүй байна.

Үнэлгээний аргачлалын 7.3.1-ийн 3 дах хэсэг дэх шалгуур буюу “төрийн байгууллагаын дарга, удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт, тэдний үлгэр жишээ байдал”-ыг АТГ-тай хамтран асуулга бүхий судалгааг тухайн байгууллагын ажилчдаас авч тус судалгааны үр дүнгээр харгалзах оноог өгсөн. (Судалгааны үр дүнг хавсаргав.)

### Үнэлгээний нэгтгэл (Яамд)

№	Яамд	Оноо
1.	Үйлдвэр хөдөө аж ахуйн яам	87,7
2.	Боловсрол, шинжлэх ухааны яам	81
3.	Барилга хот байгуулалтын яам	78
4.	Хөдөлмөрийн яам	77,9
5.	Соёл, спортын яам	66,3
6.	Зам тээврийн яам	61,8
7.	Уул уурхайн яам	60,6
8.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалалын яам	60,5
9.	Хууль зүйн яам	57,1
10.	байгаль орчин ногоон хөгжлийн яам	56
11.	Батлан хамгаалах яам	53,8
12.	Эрчим хүчний яам	53,8
13.	Эрүүл мэндийн яам	42,1
14.	Сангийн яам	41,9
15.	Гадаад харилцааны яам	25
16.	Эдийн засгийн яам	23,1
	<b>Дундаж</b>	<b>57,9</b>

### Үнэлгээний нэгтгэл (УИХ-ын дэргэдэх байгууллагууд)

Д/д	УИХ-ын дэргэдэх байгууллагууд	Оноо
1	Сонгуулийн ерөнхий хороо	72
2	Төрийн албаны зөвлөл	71,2
3	Санхүүгийн зохицуулах хороо	64,7
4	Үндэсний аудитын газар	63,2
5	Хүний эрхийн үндэсний комисс	62,1
6	Стастикийн хороо	48,3
7	Монгол банк	44,5
	<b>Дундаж</b>	<b>60,8</b>

Үнэлгээний дүнг гаргахад яамдаас Үйлдвэр хөдөө аж ахуйн яам болон УИХ-ын дэргэдэх байгууллагуудаас Сонгуулийн ерөнхий хороо авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвөлгөө төлөвлөсөн ажлыг шат дараалан хийж гүйцэтгэсэн, өмнөх жилийн алдаа дутагдалаа засаж залруулж ажилласан мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр




хангалттай ажилласан, цахим хуудсаны мэдээллийн баяжуулалт, мэдээлэл бүрэн дүүрэн, ёс зүйн чиглэлээр мэдээлэл хүлээж авах, бүртгэх зөрчил шийдвэрлэлт боломжийн түвшинд, иргэдээс гомдол мэдээлэл хүлээж авах мэдээллийн олон сувгийг үр дүнтэй ашиглаж байгаа зэрэг дэвшилт гаргасан гэдэг олон сайн үзүүлэлтээр өндөр оноо авсан байна.

Үнэлгээний дүнг баталгаажуулах зорилгоор санамсаргүй байдлаар сонгосон дөрвөн яам, 2 УИХ-ын дэргэдэх байгууллагад газар дээр нь ажиллав. Газар дээр ажиллахдаа тайлан, цахим хуудас болон бусад ирүүлсэн материалд үндэслэж хийсэн үнэлгээний үр дүн хэр үнэн зөв, бодит болохыг нягталж бодит нөхцөл байдалтай танилцах, тухайн байгууллгын авлигын эсрэг үйл ажиллаганий тайлангийн үнэн зөвийг нягтлах, холбогдох баримтыг гаргуулах, мэдээлийн ил тод байдалыг хангах чиглэлээрх ажлуудыг хэрхэн хэрэгжүүлж байгааг ажиглаж үнэлэлт өгч ажилласан болно.


Газар дээр ажиллаж үнэлгээний үр дүнг баталгаажуулахад өмнөх баримт бичгээр хийгдсэн үнэлгээнд төдийлөн их хэмжээний бодитой өөрчлөлт, ороогүй тул баримт бичгээр хийгдэж байгаа үнэлгээ үнэн зөв, бодитой гарж байна гэж дүгнэж болохоор байна. (Байгууллагуудад газар дээр ажилласан тайланг хавсралтаар хүргүүлэв.)

### Яамдын авлигын эсрэг үнэлгээний дүн 2013, 2014 оны харьцуулалт



Яамд өнгөрсөн жилийн үнэлгээгээр нийт дундаж нь 53 оноо байсан бол 2014 онд нийт дундаж нь 57,9 болж дээшлэсэн байна. Мөн зарим яамд тухайлбал Барилга хот, байгуулалтын яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Боловсрол шинжлэх ухааны яам зэрэг нь өмнө оны үнэлгээгээр гарсан оноо алдсан ажлуудыг засаж залруулж, санал, санаачлагатай ажилласанаар 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний дүнг амжилттай ахуилж чадсан байна. Хэдий тийм боловч өмнөх жилийн хүрсэн үр дүнгээсээ ухарсан яамд байгааг ч бас дурьдах хэрэгтэй.

**УИХ-ын дэргэдэх байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ харьцуулалт**



УИХ-ын дэргэдэх байгууллагуудын хувьд өмнө жилийн дундаж үнэлгээ 50,8 байсныг энэ онд 60,8 болгон ахиулсан нь томоохон амжилтанд хүрсэн байна гэж үзэхээр байна. Энэ нь төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний ажил тодорхой үр дүн, зорилтдоо хүрч байгааг харуулж байна.

**ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

Үнэлгээний үр дүнг нэгтгэн байгууллага бүрийн тухайн шалгуурт авсан оноо гүйцэтгэлийн хувийг гарган тооцож нийт үнэлгээнд дүн шинжилгээ хийж ажилласан болно. (Хавсралт-3)

Яам болон УИХ-ын дэргэдэх байгууллагуудын үнэлгээний хүснэгт дэх хуулиар хүлээсэн үүргийн биелэлт болон авлигын эсрэг үйл ажиллагааны санал санаачилга, гүйцэтгэлийн дундаж нь **59,3** хувийн биелэлт үнэлгээ авч байна.

Шалгуур үзүүлэлтийн бүлэг тус бүрийн гүйцэтгэлийн хувь хэмжээг дороох хүснэгтээр харуулав. (Шалгуур үзүүлэлт тус бүрийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй гүйцэтгэлийн хувь, оноог Хавсралт-2)

Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт		62,4
9.1.1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	63,5
9.1.2	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	67,5
9.1.3	Төрийн хяналтынүйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	43,5
9.1.4	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	67,5
9.1.5	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил	60,7

	тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	
<b>9.1.6</b>	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	58,3
<b>9.1.7</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	59,4
<b>9.1.8</b>	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	74
<b>9.1.9</b>	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	47,2
<b>9.1.10</b>	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	81,6
<b>9.1.11</b>	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	63,2
<b>9.1.12</b>	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	50,0
<b>9.1.13</b>	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	62,5
<b>9.1.14</b>	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах	68,8
<b>9.1.15</b>	Авлигын эрдэл ба авлига гарах боломжийг бууруулах	45,8
<b>9.1.17</b>	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	86,6
<b>Авлигатай тэмцэх санал санаачлага</b>		<b>34</b>
<b>10.1.1</b>	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	60,1
<b>10.1.2</b>	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт	14
<b>10.1.3</b>	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	25,4

#### ХАМГИЙН ӨНДӨР ОНОО, ХУВИЙН БИЕЛЭЛТ ҮЗҮҮЛСЭН АЖЛУУД

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт хэрэгжүүлэлтийн байдал 80%
- Эрх бүхий албан тушаалтаныг томилсон, ажлын байрны тодорхойлолтонд тусгасан, холбогдох нэмэлтийг өгсөн байдал 77,1%
- Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулсан байдал 64,6%
- Удирдлагын шийдвэрийг нээлттэй ил тод байдлыг хангах-64,6%
- Ажилтан албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлаж мөрдүүлсэн байдал 72,9%
- Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцлийг бүрдүүлсэн байдал 67,5%

#### ХАМГИЙН БАГА ОНОО, ХУВИЙН БИЕЛЭЛТ ҮЗҮҮЛСЭН АЖЛУУД

- Төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг тусгайлан төлөвлөж, санхүүжүүлсэн байдал 6,7%
- Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/22,7%

- Тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар танилцуулсан байдал 22%
- Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байдал 2%
- Авлигын эсрэг ТББ, хуулийн этгээдээс гаргасан санал санаачлалгыг дэмжиж ажиллсан байдал 2%
- Давхар эрхэлж болох ажлын байрны жагсаалт гаргах 41,7%
- Төсвийн орлого бүрдүүлэлтийн талаар дэлгэрэнгүй тайлагнах 31%

## ОЛОЛТ АМЖИЛТ

Яамд, УИХ-ын дэргэдэх байгууллагуудаас 2014 онд авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ нийтлэг байдлаар зарим ололт, амжилтанд хүрчээ.

- Мэдээллийн самбар, мэдээллийн ухаалаг самбар зэрэгт холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ард иргэдэд мэдээлэл хүргэж хэвшсэн.
- Өргөдөл гомдол, мэдээлэл утас, санал хүсэлтийн хайрцаг зэргээр хүлээн авч хэвшиж өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах сувгийг нэмэгдүүлсэн байна.
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдал хангагдаж холбогдох мэдээллүүдийг цахим хуудсандаа байршуулж хэвшсэн байна.
- Яамд нь өөрийн байрны үүдний танхимд мэдээллийн ухаалаг дэлгэц байршуулан яамны бүтэц зохион байгуулалт, алба хэлтэс, тэдгээрийн нэр хаяг, сайдын шийдвэрүүдийг үзэх, холбогдох бүхий л мэдээллийг хүлээн авах боломж бүрдүүлж иргэд хүлээн авах ажилтан ажиллуулж яамны үйлчилгээг хүлээн авахаар ирсэн иргэд, ААН, байгууллагын төлөөллийг хүлээн авч яамны заавар зөвлөмж өгч тухайн асуудлаар холбогдох мэргэжилтэнтэй нь холбож өгч байгаа нь яамны үйлчилгээг иргэд ойртуулах, хүндрэл чирэгдлийг багасгахад чиглэсэн амжилттай үйл ажиллагаа болжээ.
- Яамд Авлигын эсрэг хамтдаа тугайлсан самбар байршуулж, Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг байршуулж хэвшсэн байна.

## САЙН ТУРШИЛГА

Яамд, УИХ-ын дэргэдэх байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж зохион байгуулахдаа бусад байгууллагад авч хэрэгжүүлж болохуйц шинэ оновчтой санал санаачлага гарган ажилласан байгууллагууд цөөнгүй байна. Үүнд:

- Үйлдвэр хөдөө аж ахуйн яам авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан төлөвлөгөөг АТГын “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу гаргаж ажлыг шат дараалан хэрэгжүүлж, тухайлсан арга хэмжээг тогтмол болгон хэрэгжүүлсэн, нээлттэй ил тод байдлыг хангах, цахим хуудсаны мэдээллийн хөтлөлт баяжуулалт сайн, авлигын эсрэг үйл ажиллагааны санхүүжилтийг хангалттай гарган ажилласан зэргээр 2014 онд авлигын эсрэг үйл ажиллагааг хангалттай түвшинд зохион байгуулжээ.
- Хүний эрхийн үндэсний комисс нь Байгууллагын дотоод сүлжээнд [www.able.mn](http://www.able.mn) цахим хуудсыг нэвтрүүлсэнээр мэдээллийг хоорондоо түргэн шуурхай дамжуулах, шинэ гарсан заавар тушаал чиглэлийг түгээх, түүний дагуу ажлын гүйцэтгэлийг шаардах бүхий л үйл явцыг цогцоор нь шийдвэрлэсэн сайн санаачлага болсон

байна. Мөн Комиссын дэргэд хүний эрхийн сэтгүүлчдийн клуб байгуулж удирдлага арга зүйгээр хангаж тэднээр өөрсдийн үйл ажиллагааг нийтэд мэдээллүүлж, сурталчилж мөн тэднээр асуудал хөндсөн нийтлэл бичүүлэх зэргээр хамтарч ажиллаж байна.

- Барилга, хот барилга хот байгууллагын яам гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээний талаарх мэдээллийг цахим хуудсанд видео хэлбэрээр ил тод нээлттэй байршуулсан байна

## ДУТАГДАЛТАЙ ТАЛ

Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагууд 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ нийтлэг байдлаар дараах дутагдалтай байдал гаргасан байна.

Авлигын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ арга зүйн хувьд дараах алдаа дутагдлыг нийтлэг байдлаар гаргасан байна. Үүнд:

- Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүг төлөвлөж баталдаггүй гэх шалтгаанаар хэрэгжүүлээгүй гэх шалтгаанаар авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгаагааг тайлбарлаж, хаацаалах түгээмэл хандлагатай.
- Хоорондын ажлын уяалдаа холбоо хангалтгүй, ЭБАТ өөрийн чиг үүргийн хүрээнд холбогдох хэлтэс, ажилтануудаасаа шаардлагатай мэдээллийг бүрэн дүүрэн авч чаддаггүй. Мөн Мэдээллийн ажилтантайгаа хамтран ажиллаж мэдээллийн ил тод байдлыг хангах, цахим хуудас дах ил тод байх мэдээллийг цаг тухай бүр байршууллуулан, цахим хуудсын мэдээллийн бүрдэлийг тухай бүр хянаж ажиллаж чадахгүй байна.
- Тогтмол хэрэгжүүлэх ажлыг бүрэн дүүрэн тогтмол болгож хэрэгжүүлэлгүй нэг удаагийн арга хэмжээ болгон өнгөрөөх байдал түлхүү ажиглагдлаа.
- Цахим хуудсуудын мэдээлэл дутуу, байх ёстой мэдээллүүд байхгүй, агуулга бүрэн бус, зарим дэд хэсэгт алдаа заадаг, эмх цэгцгүй, иргэд өөрт хэрэгтэй мэдээллийг олж авахад хүндрэлтэй, нэгдсэн нэг загвар зохион байгууллалтгүй;
- Үнэлгээний аргачлалд тусгагдсан зарим арга хэмжээний талаар мэдээлэл, ойлголт дутмаг, тухайн арга хэмжээний талаар юу хийхээ мэддэггүй. Хамааралгүй зүйлсийг тусгаж тайлагнадаг

Дээрх алдаа дутагдалууд нь тухайн байгууллагын удирдлагын санал санаачлага, зохион байгуулалтын алдаа утагдал, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэг хүлээсэн албан тушаалтаны мэдлэг ур чадварын дутагдалтай байдлаас шалтгаалсан болох нь харагдаж байна.

## СУДАЛГААНЫ ДҮН

Үнэлгээг хийх явцдаа тухайн байгууллагын удирдлагын авлигын эсрэг үйл ажиллагаанд хандах хандлага, авлигын эсрэг хүсэл эрмэлзэл, авлигын эсрэг үйл

ажиллагааг санхүүжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг тодруулах зорилгоор АТГ-тай хамтран 12 асуулт бүхий судалгааг ажилчдаас авсан болно.

Судалгаанд Яамд, УИХ-ын дэргэдэх байгууллагууллагуудын нийт 179 албан хаагч хамрагдсан нь тухайн байгууллагад ажилладаг нийт ажилчин албан хаагчдийн 9,3 хувийг эзлэж байна.


Судалгаанд санамсаргүй түүвэрлэлтийн зарчмын дагуу нийт албан хаагчийн 10 буюу түүнтэй ойролцоо хувийг хамруулж чадсан тул тухайн судалгааны үр дүн судалгаанд хамрагдсан байгууллагын нийт алба хаагчдыг төлөөлж болохуйц тул үр дүнг бодитой гэж үзэх үндэслэл болно.

#### Судалгааны үр дүн

№	Асуулт	Хариулт	Хувь	
			Яамд	УИХ-ын байгууллага
1	Танай байгууллагын авлига авах замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр нэг бүрийг та мэдэх үү?	1 мэднэ	40,5	35,6
		2. Би мэдэхгүй	31,6	40
		3. Миний эрхэлж буй албан үүргийг хүрнээд мэдэх шаардлагагүй мэдээлэл байна.	21,5	20
2	Аливаа этгээд танай байгууллагын хэн нэгэнд, магад таньд авлига өгөхийг хүсэхэд та тэргүүн ээлжинд хаана хандах вэ?	1. Хэнд ч хэлэхгүй. Энэ мэдээллийн төлөө гарч болох эрсдэлээс хамгаалалт байхгүй	12,7	6,7
		2. АТГ-д хэлнэ. Байгууллагын дотор авлига өгөхийг хүссэн этгээдтэй холбоотой хүн байгаа ч юм билүү	19,8	15,6
		3. Шууд АТГ-д хэлнэ. Манай байгууллагын хэн гэдэг албан тушаалтанд энэ тухай мэдээлэл өгөх нь тодоххой биш	15,7	8,9
		4. Эхлээд байгууллагадаа хэлнэ. Манай байгууллага намайг хамгаална гэдэгт итгэдэг.	51,6	62,2
3	Таны албан үүргээ гүйцэтгэж буй байгуулла “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг танилцуулдаг уу?	1. Тийм	77,2	83,3
		2. Энэ тухай мэдээлж байгаагүй	27,8	14,4
5.	Танай байгууллагад авлигад өртөж болзошгүй ажлын	1. Байдаг	36,5	31,1


	байрны жагсаалт байдаг уу?	2. мэдэхгүй	52,2	48,9
		3. Байдаггүй	10,3	17,8
<b>6</b>	Танай байгууллага авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажилд зарцуулагдах зардлыг төсөвтөө тусгаж батлуулдаг уу.	1. Тийм	31,9	51,1
		2. Мэдэхгүй	54	44,4
		3. Байдаггүй	12,4	2,2
<b>7</b>	Танай байгууллага ирэх жилийн батлагдсан төсвөө танилцуулдагуу	1. Тийм	57,5	80
		2. Үгүй	33,9	17,8
<b>8</b>	Танай байгууллага ирэх жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авдаг уу.	1. Тийм	53,2	70
		2. Үгүй	38,7	27,8
<b>9.</b>	Танай байгууллага авлигаас ангид үйл ажиллагаа явуулж байна уу.	1. Би авлигаас ангид байгууллагад ажилладаг	75,7	88,9
		2. Авлига байх орчин нөхцөл манай байгууллагад байгаа	20,2	6,7
<b>10</b>	Та хэн нэгэн авлига авсан тухай нотолгоо бүхий мэдээлэлтэй байгаа нөхцөлд энэ тухай эрх бүхий байгууллагад мэдээлж чадах уу?	1. Чадна, мэдээлэл өгсөн этгээдийг хэрхэн хамгаалах талаар ойлгомжтой эрх зүйн зохицуулалт тогтолцоотой бол өгч чадна.	40,4	52,2
		2. Үгүй, мэдээлэгчийг хамгаалах тогтолцоо ойлгомжгүй, тодорхой бус тул	16,7	11,1
		3. Ямарч тохиолдолд өгнө.	26,8	23,3
		4. Эрх бүхий байгууллага мэдээлэл өгөхийг эрх хэмжээнийхээ хүрээнд шаарвал өгнө.	15,5	6,7
<b>11</b>	Таны удирдлага таны хуулийн дагуу боловсруулсан баримт бичгийг өөрийн болон бусдын ашиг сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу?	1. Үгүй	66,6	47,8
		2. Өөрчлөлт ордог, хуульд нийцсэн зөвлөмж өгч	26,9	47,8
		3. Өөрчлүүлдэг	5	
		4. Өөрчлөл гэдэг би хуулийн дагуу ажлаа өөрчлөггүй.		

**Асуулга-1 Танай байгууллагын авлига авах замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр нэг бүрийг та мэдэх үү?**



Тухайн асуулгад нийт судалгаанд оролцогчдийн 35-40 орчим хувь нь өөрийн байгууллагад авлигын замаар шийдвэрт нь нөлөөлөх боломжтой гэж хариулж байгаа нь тухайн байгууллагад авлигын зөрчил гарах магадлал боломжтой бөгөөд тэр нь дотор ажиллаж байгаа ажилтан албан хаагчидад мэдэгдэж тодорхой байгаа нь харагдаж байгаа нь нилээд анхаарал татаж байна.


**Асуулга 2 Аливаа этгээд танай байгууллагын хэн нэгэнд, магад таньд авлига өгөхийг хүсэхэд та тэргүүн ээлжинд хаана хандах вэ?**



Дээрх судалгааны дүнгээс үзэхэд ажилтан албан хаагчидад байгууллага болон түүний удирдлагадаа итгэх итгэл өндөр байгааг харуулж байна.




**Асуулга 3 Таны албан үүргээ гүйцэтгэж буй байгуулла “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг танилцуулдаг уу?**




Тус судалгааны дүнгээс яам, УИХ-ын дэргэдэх байгууллагууд ажилтан албан хаагчиддаа авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулж ажиллаж хэвшсэн үр дүн үзүүлж байна.

**Асуулга 7 Танай байгууллага ирэх жилийн батлагдсан төсвөө танилцуулдаг уу**




Байгууллагын төсвийн мэдээллийг ажилтан албан хаагчиддаа танилцуулж дотоод ардчилал, хяналт, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байгаа болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.

**Асуулга 8 Танай байгууллага ирэх жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал авдаг уу.**



Судалгааны тус хэсгийн дүнгээс харахад авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал авах байдал харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Иймд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа дотоод ажилтан албан хаагчдын санал, санаачлагыг авч төлөвлөгөөг боловсруулж хэвших нь тухайн төлөвлөгөө бүрэн дүүрэн биелэх суурь нөхцлийг бүрдүүлнэ.

**Асуулга 11 Таны удирдлага таны хуулийн дагуу боловсруулсан баримт бичгийг өөрийн болон бусдын ашиг сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан удаа бий юу?**



Тухайн асуултанд судалгаанд хамрагдын дийлэнх олонх нь үгүй болон хуульд нийцүүлж өөрчилдөг гэж хариулсан байх боловч бас тодорхой хувь нь ашиг сонирхолын зөрчилтэйгээр хууль бусаар шийдвэрийг өөрчлөж байсан гэж хариулсан байгаа нь үнэлгээнд хамрагдаж буй байгууллагуудад авлига ашиг сонирхолын зөрчил тодорхой хэмжээгээр байгааг харуулж байна.

Яамд болон УИХ-ын дэргэдэх байгууллагууд болох нийт 23 байгууллагын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг нийт байгууллагын төлөвлөгөө, тайлан, холбогдох нотлох баримт, цахим хуудас болон бусад эх сурвалжийг ашиглан үнэлгээ өглөө.

Үнэлгээний дүнг баталгаажуулах, чанаржуулах үүднээс санамсаргүй сонголтын зарчмаар 4 яам, 2 агентлаг дээр судлаачид биечлэн очиж газар дээр нь ажилласан болно.

Үнэлгээг Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 11 сарын 14-ны 122 тоот тушаалын хавсралтаар баталсан “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал” –аар буюу 2 үндсэн бүлэг 79 дэд үзүүлэлтээр шалгаж боломжит 100(+10) оноогоор үнэлгээг хийхэд яамдын хувьд 57,9 УИХ-ын дэргэдэх байгууллагуудад 60,8 гэсэн дундаж оноо авсан байна.

2014 оны “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны үнэлгээний дундаж оноо нь өмнөх оны үнэлгээний дундаж оноогоос өссөн байгаа тухайн байгууллагуудад “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулуулан хэрэгжүүлүүлж үнэлгээг явуулж эхэлсэн нь үр дүнгээ өгч байгаа нь харагдаж байна.

Үнэлгээ хийх явцад авлигын эсрэг үйл ажиллагааг зөвхөн тайлан гаргах гэж нэг удаагийн хэлбэр төдий үйл ажиллагаа болгон явуулах нийтлэг алдаа дутагдал гарч байна.

Иймд Авлигын эсрэг үйл ажиллагааны авлигын гэмт хэрэг, зөрчил түүний учруулах хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх өндөр ач холбогдолтой тасралтгүй үргэлжлэх үйл явц гэдгийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, удирдлага, ажилчдад нэг мөр ойлголт, итгэл үнэмшлийг бий болгох шаардлагатай байна.

Авлигын эсрэг зарим үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй шалтгаанаа тухайн ажилд зарцуулах төсөв батлагдаагүй гэдэг тайлбарлаж байгаа боловч тухайн үнэлгээний аргачлалаар шалгаж буй ажлуудын ихэнх хувь нь мөнгө хөрөнгө шаардахгүйгээр хэрэгжүүлж болох зохион байгууллалтын шинжтэй ажлууд байгаа болно.

Үнэлгээний 70 онооны шалгуур үзүүлэлт нь тухайн байгууллагад хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн хангалтаар шалгаж байгаа бөгөөд үнэлгээнд хамрагдсан байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлт 62.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна.

Тухайн ажлууд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн эсэхээс үл хамааран тухайн байгууллагад хуулиар хэрэгжүүлэх ёстой үйл ажиллагаа тул Монгол Улсын төрийн захиргааны төв байгууллагууд өөрсдөө хуулийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн хангаж ажиллахгүй байгаа нь энэхүү үнэлгээний үр дүнгээс харагдаж байна.

Мөн Авлигын эсрэг байгууллага, удирдлагын санал санаачлагыг үнэлэх дэд хэсгээр дундаж үзүүлэлт 33,2 хувьтай байгаа нь авлигын эсрэг санал санаачлага, идэвхи чармайлт дутуу дульмаг байгаа нь харагдаж байна.

Шинжээчдийн багаас яамд, УИХ-ын дэргэдэх байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх явцад тэдгээрийн гаргаж буй нийтлэг алдаа дутагдал, авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч буй бэрхшээлийг өөрсдийн шинжилгээ, судалгаа, ажиглалтын явц, үр дүнг үндэслэн тодорхойлж, тэдгээрийг арилгах, засан сайжруулах, цаашид авлигын эсрэг үйл ажиллагааний хэрэгжилтийн бүрэн дүүрэн байдал, үр дүнг нэмэгдүүлэх үүднээс арга зүйн хувьд үнэлгээнд хамрагдаж буй байгууллага болон Авлигатай тэмцэх газарт хандсан санал, зөвлөмжийг өгч байгаа болно.

Яамд, УИХ-ын дэргэдэх байгууллагуудад дараах арга хэмжээг дотооддоо авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Төлөвлөгөө боловсруулахын өмнө өөрийн байгууллагад авлига гарах боломж бүрдүүлж буй шалтгаан нөхцлийг тодруулах талаар иргэний нийгмийн байгууллагаар судалгаа хийлгэж, тухайн нөхцөл шалтгааныг арилгах чиглэлд төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг сайтар судалж, ойлгомжгүй, тодорхойгүй асуудлуудын талаар Авлигатай тэмцэх газрын холбогдох мэргэжилтэнүүдээс зөвлөгөө, туслалцаа авч ажиллах;
- Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Эрх бүхий албан тушаалтан болон бусад ажилчидын чиг үүрэг ажлын уялдаа холбоог хангаж Эрх бүхий албан тушаалтаны өөрийн чиг үүргийн дагуу гаргах шийдвэр түүний биелэлтийг хангах механизмыг дотоод дүрэм, журмын хүрээнд тусгаж баталгаажуулах;
- Авлигын эсрэг хууль, Мэдээллийн илт тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээх үүргийн биелэлтийг нэг мөр хангаж ажиллах;
- Төсөв батлагдаагүй гэдэг шалтгаанаар авлигын эсрэг зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй, орхихгүй байх, дотоодын нөөц бололцоо мөн тухай ажлыг мөнгө хөрөнгө зарцуулалгүйгээр хийж хэрэгжүүлж болох арга замыг хайх;
- Авлигын эсрэг үйл ажиллагааг нэг удаагийн бус тогтмол хэрэгждэг үргэлжилсэн шинжтэй үр дүнтэй арга хэмжээ болгон зохион байгуулж хэрэгжүүлэх;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж ажиллах, тус орон тооны бус зөвлөлөөр авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг сар бүр дүгнэж байх.
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хамт олноороо хэлэлцүүлэн хэрэгжилтийн талаар танилцуулдаг, жилийн эцэст гүйцэтгэлийг нь хамт олонд тайлагнаж хэвших;
- Авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтэнд дотоод хяналтын нэгж давхар хяналт тавьдаг байх;

#### АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Авлигатай тэмцэх газраас төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны зохион байгуулалт, хамрах хүрээ, үр дүн нэмэгдэхийн тулд авлигын эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих эрх, үүргийнхээ хүрээнд дараах ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтнуудыг нэгдсэн байдлаар “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжүүлэлт, тайлагналт”-тай холбогдсон сургалтанд хамруулж, идэвхижүүлэх. Үүндээ энэ чиглэлийн мэргэжлийн сургалтийн байгууллага, төрийн бус байгууллагыг татан оролцуулах;
- Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулалтыг хангахад шаардагдахаар төсөвлөсөн хөрөнгийг батлаж байх, төсвийн төслөөс хасахгүй байх талаарх хүсэлтийг Сангийн яам, Засгийн газарт хүргүүлэх;
- Яамд, УИХ-ын дэргэдэх байгууллагуудын цахим хуудсыг нэгтсэн нэг загварт оруулж иргэд мэдээлэл хайх олж авахад амар дөхөм болгох талаар холбогдох байгууллагуудтай хамтран зөвлөмж, загвар боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Өмнөх жилийн авлигын эсрэг үйл ажиллагаанаас үнэлгээгээ бууруулж амжилтаасаа ухарсан байгууллагуудад холбогдох арга хэмжээ авах;
- Авлигатай тэмцэх газартай холбогдсон авлигын эсрэг үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгаа, санал санаачлага гарган ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын талаарх мэдээлэлийг үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад хүргэх;

## ХАВСРАЛТ

- Байгууллагуудын үнэлгээний хуудас-(16 Яам, 7 УИХ-ын дэргэдэх байгууллага)
- Үнэлгээний дүнд хийсэн шинжилгээ
- Байгууллагуудаас авсан судалгааны нэгтгэл
- Байгууллагуудад газар дээр нь ажилласан тухай тайлан- (4 яам, 2 УИХ-ын дэргэдэх байгууллага)

### Ашигласан материал, эх сурвалж

#### Нэг. Хууль тогтоомж

- ✓ Авлигын эсрэг хууль
- ✓ Нийтийн албанд хувийн болон нийтийн ашиг сонирхолын зөрчлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- ✓ Мэдээллийн ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль

#### Хоёр. Баримт материал

- ✓ “Төрийн байгууллагын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”
- ✓ Байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллаганы төлөвлөгөө тайлан, хавсралтаар ирсэн нотлох баримтууд,
- ✓ Байгууллагын цахим хуудас,
- ✓ Газар дээр нь ажиллаж гаргуулан авсан баримт, нотолгоо,
- ✓ Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийн бүртгэл,
- ✓ Авлигатай тэмцэх газраас авагдсан зөрчил арилгуулах, хариуцлага оногдуулсан арга хэмжээний бүртгэл,
- ✓ Тухайн байгууллагуудтай холбогдох авлигатай тэмцэх газарт ирүүлсэн өргөдөл гомдолын бүртгэл,
- ✓ Үнэлгээнд хамрагдаж буй байгууллагын албан тушаалтанаас авлига, албан тушаалын гэмт хэрэгт шийтгэгдсэн мэдээлэл, судалгаа,
- ✓ Асуулгын судалгааны дүн,

## ХАВСРАЛТ 2

Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Шалгуур		Хувь
		Гүйцэтгэлийн үзүүлэлт		
9.01.01	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах	9.1.1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	58,3	63,5
		9.1.1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх	68,8	
09.01.02	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох	9.1.2.1. Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх	54,2	60,8
		9.1.2.2. Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх	61,7	
		9.1.2.3. Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх	66,7	
09.01.03	Төрийн хяналтын үйл ажиллагааны илтөд, нээлттэй байдлыг хангах	9.1.3.1. Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/ цахим хуудсандаа байршуулсан байх	32,5	43,5
		9.1.3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/	50,0	
		9.1.3.3. Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ/дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх	47,9	

07.01. 04	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	9.1.4.1. Тухайн жилийн төсөв/1 дүгээр сарын 10ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15ны дотор/ийг цахим хуудсандаа байршуулах	60,4	67,5
		9.1.4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1ний дотор/г цахим хуудсандаа байршуулах	45,8	
		9.1.4.3.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 1ний дотор/ийг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах	66,7	
		9.1.4.4.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/	54,2	
		9.1.4.5.Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/	31,3	
		9.1.4.6. Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан нийтэд мэдээлэх	91,7	
		9.1.4.7.Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх	91,7	
		9.1.4.8.Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/ийг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	100,0	
		9.1.4.9.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	77,1	
		9.1.4.10.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах	56,3	
9.1.5	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах	9.1.5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	68,8	60,7
		9.1.5.2.Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	47,9	



	боломжоор хангах	9.1.5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	62,9	
		9.1.5.4.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох	63,3	
09.01.06	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	9.1.6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/	54,2	58,3
		9.1.6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх	62,5	
09.01.07	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	9.1.7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах	64,6	59,4
		9.1.7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	60,4	
		9.1.7.3.Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх	66,7	
		9.1.7.4.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсанболон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/ийг цахим хуудсанд байршуулах	56,3	
		9.1.7.5.Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх	56,3	
		9.1.7.6.Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх	70,8	
		9.1.7.7.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	47,9	
		9.1.7.8.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	52,1	
09.01.08	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	9.1.8.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх	72,9	
		9.1.8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	75,0	
09.01.09	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус	9.1.9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх/1 ба түүнээс	37,5	47,2

	байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	<i>дээш/</i> 9.1.9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх	50,0	
		9.1.9.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараамэдээлсэн байх	54,2	
09.01.10	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	9.1.10.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх	70,8	81,6
		9.1.10.2.ЭБАТын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх	77,1	
		9.1.10.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх	87,5	
		9.1.10.4.ЭБАТын үйл ажиллагааг үнэлэх	90,8	
09.01.11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	9.1.11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх	79,2	63,2
		9.1.11.2.Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх/албан хаагчдад танилцуулсан байдал/	68,8	
		9.1.11.3.Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл / <i>тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/ийг бүрдүүлсэн байх</i>	58,3	
		9.1.11.3.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/г авах	58,3	
		9.1.11.4.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	58,3	
		9.1.11.5.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	56,3	
09.01.12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	9.1.12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх	41,7	50,0
		9.1.12.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх	58,3	

09.01. 13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	9.1.13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/	64,6	62,5
		9.1.13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/ийг цахим хуудсандаа байршуулах	62,5	
		9.1.13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах	70,8	
		9.1.13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах	52,1	
09.01. 14		9.1.14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх	62,5	68,8
		9.1.14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	87,5	
		9.1.14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	66,7	
		9.1.14.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх	58,3	
09.01. 15		9.1.15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх	35,4	45,8
		9.1.15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/	56,3	
09.01. 16		Төрийн байгууллагад түүний үйлчилгээг эрхэлдэгээс бусад аж ахуй нэгж байхыг хориглоно.	100	
09.01. 17		9.1.17.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	91,7	86,6

		9.1.17.2.АТГын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	100,0	
		9.1.17.3.АТГаас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ	100,0	
		9.1.17.4.АТГаас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт	100,0	
		9.1.17.5.Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх	50,0	
		9.1.17.6.АТГын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ	77,9	
Дэд хэсэг	Авлигатай тэмцэх санал, санаачлага			
09.01.02	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	9.1.2.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх	60,4	60,1
		9.1.2.2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх	80,0	
		9.1.2.3.Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15ны дотор/нд АТГт хүргүүлсэн байх	68,8	
		9.1.2.4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх	31,3	
09.01.02		9.1.2.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/д нэгдсэн байдал	20,8	25,5
		9.1.2.2.Удирдах албатушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал		
		9.1.2.3.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/	33,3	
		9.1.2.4.Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ	47,8	
09.01.03		9.1.3.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/г авах	58,0	16,3

	9.1.3.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ	27,5
	9.1.3.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ	41,7
	9.1.3.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ	
	9.1.3.5 Шүүхээр шийдэгдсэн болон Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил	20,8